


Монгол Улсын Зэвсэгт Хчний тvvхэнд дорвитой хувь нэмэр оруулсан дивизийн нэг бол Монгол Ардын Хувьсгалт Цэргийн 7 дугаар морьт дивиз юм.

Тvvхийн шарласан хуудсыг сохон vзвэл одоогоос 75 жилийн омно болж онгорсон 1945 оны Чолоолох дайнд оролцож, байлдааны vvргээ нэр тортэй гvйцэтгэсэн Монгол Ардын Хувьсгалт Цэргийн дорвон морьт дивизийн нэг болох Байшинтын хэмээн алдаршсан долоодугаар морьт дивизийн гvйцэтгэсэн vvрэг, тvvхэнд эзлэх байр суурь, туулсан замналын талаар дагнасан судалгааны бvтээл хийгдээгvй.

Цэргийн тvvх бичлэгт 5, 6, 8 дугаар морьт дивизvvд Халхын голын дайнд оролцож vvрэг гvйцэтгэсэн талаар цоонгvй бvтээл туурвигдсан байдаг бол 7 дугаар морьт дивизийн талаар тvvх бичлэгт бага хэмжээтэй дурдсанаас гадна зовхон Чолоолох дайны vед “Омнод” бvлгийн бvрэлдэхvvнд оролцож байлдсан талаар товч огvvлсэн байдаг.

Тус дивизийн бие бvрэлдэхvvн улс торийн хэлмэгдvvлэлтийн vе шатыг хэрхэн даван туулсан, Халх голын дайн ба Чолоолох дайны vеэр дээд удирдлагаас огсон vvрэг даалгаврыг хэрхэн биелvvлж байсныг цэргийн тvvх бичлэгт орхигдуулжээ.

Иймийн учир судлаач хошууч Н.Хvдэрбат нь энэхvv бvтээлдээ **нэгдvгээрт:** Он цагийн хувьд Монгол оронд vндэсний ардчилсан хувьсгал ялсан 1921 оноос хойших 24 жилийг хамарсан буюу энэ хугацаанд МАХЦ-ийн тvvхэнд болж онгорсон vйл явдлын дэвсгэр дээр 7 дугаар морьт дивиз vvсэн байгуулагдаж, туулсан замналыг тоймлон харуулсан.

Мон 1927 оноос омно ба хойш 3 дугаар суман, нутгийн морьт дивизион, 3 дугаар морьт дивизион, нутгийн 3 дугаар морьт хорооны удирдах бvрэлдэхvvнд ямар хvмvvс ажиллаж байсан тvvнчлэн 1932 оноос 1945 он хvртэл МАХЦ-ийн дивиз, хороо, дивизионуудад ямар зэвсэг, техник хэрэгсэл хэрэглэгдэж байсныг товч дурдсан.

**Хоёрдугаарт:** 7 дугаар морьт дивиз Монгол Улсын тусгаар тогтнол, эх орноо батлан хамгаалах vйл хэрэгт хэрхэн оролцсоныг архивын баримтад тулгуурлан тодруулж нийтийн хvртээл болгохыг эрмэлзсэн.

Харин Yндэсний тов архив болон Тагнуулын еронхий газрын архивт хадгалагдаж байгаа зарим баримт материалуудыг нягтлан vзэхэд цаг хугацаа нилээд шаардагдах тул 1936 оны 7 дугаар сараас 1939 оны сvvл хvртэлх тvvхэн vйл явдлыг цухас тодий дурдсан. **Гуравдугаарт:**
Судалгааны бvтээлийн хавсралтад дивиз болон морьт хороодын удирдах бvрэлдэхvvнд алба хааж байсан 185 цэргийн алба хаагч (
*зарим цэргийн алба хаагчийн овог тодорхой бус*
)-ийн намтрыг товч байдлаар оруулсан.

Мон 1936-1938 оны эцэс хvртэл тус дивизээс ямар учир шалтгаанаар цэргийн алба хаагчид нас барсан учир шалтгааныг тодруулах, овчноор нас барсан 181 цэргийн алба хаагчийн овог нэр, аймгийн харьяалалаар нь тодруулан гаргасан.

Дивизийн болон харьяа анги, салбаруудаас улс торийн хилс хэрэгт хэлмэгдсэн 111 цэргийн алба хаагчийн товч намтар болон тус ангиас ажлын гараагаа эхэлсэн цэргийн нэрт зvтгэлтэн 6 генерал, 32 хурандаагийн товч намтрыг лавлагаа, мэдээлэл судалгааны хэрэглэгдэхvvн болгох зорилгоор оруулсан.